АЖЛЫН БАЙР (АЛБАН ТУШААЛ)-НЫ ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☐ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

☑ Байгууллагын зохион байгуулалтын бүтэц, орон тоонд өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомж, шийдвэрийн нэр, огноо: "ИНҮТ" ТӨХХК-ийн гүйцэтгэх захирлын 2025 оны А/49 дүгээр тушаал

Албан тушаалын тодорхойлолтын дугаар: "ИНҮТ" ТӨХХК - 48

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо, дугаар: 2025.03.14 А/124

Байгууллагын нэр:	Нэгжийн нэр:
"Иргэний нисэхийн үндэсний төв" ТӨХХК	Аюулгүй байдал, чанарын удирдлагын газар
Албан тушаалын нэр:	**Албан тушаалын ангилал, зэрэглэл:**
Аэродром, гэрэл суулт, цахилгааны үйлчилгээний аюулгүй байдлын ахлах технологич мэргэжилтэн	
Ажлын цаг:	**Ажлын байрны албан ёсны байршил:**
Ердийн	ХУД-ийн 21-р хороо, "ИНҮТ" ТӨХХК
Хөдөлмөрийн нөхцөл:	**Онцгой нөхцөл:**
Хэвийн	

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Компанийн аюулгүй байдал, чанарын удирдлагын баримт бичгийг ИНД болон холбогдох ОУИНБ-ын баримт бичгт нийцүүлэн боловсруулах, ИНД-үүдийн хүрээнд боловсруулагдсан үйл ажиллагааны ерөнхий заавар болон аэродром, гэрэл суулт, цахилгааны үйлчилгээний холбогдох баримт бичгүүдийг хянах, аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог хангуулах, дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах, удирдлагыг хяналт шалгалтаар илэрсэн дутагдлыг арилгахад чиглэсэн бодит баталгаа бүхий үнэлэлт, дүгнэлт, зөвлөмжөөр хангах, үр нөлөөг тооцоолох, болзошгүй алдаа, дутагдлыг илрүүлэх, сайжруулах арга хэмжээг авах

Албан тушаалын зорилт:

1. Компанийн аюулгүй байдал, чанарын удирдлагын баримт бичгийг боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих, холбогдох заавар, журмуудыг хянах;
2. Аэродром, гэрэл суулт, цахилгааны үйлчилгээний үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хяналт тавих, шалгалт хийх, үл тохирлыг илрүүлэх, түүнийг арилгах зөвлөмж дүгнэлт гаргах, залруулах арга хэмжээг авах, (SPIs)-ийн зорилтот түвшинд хүргэх арга хэмжээг хэрэгжүүлэх;
3. Аюулгүй байдал, чанартай холбоотой эрсдэлийн үнэлгээ хийх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтийг хангах;
4. Аюулгүй байдал, чанарын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх, технологи үйл ажиллагаа болон бусад бүх үйл явц, үйл ажиллагаанд идэвх санаачлагатай манлайлан оролцож, багаар хамтран ажиллах;
5. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж, стандартыг хэрэгжүүлэх;

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан

			гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх-Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.1. Компанийн болон газрын үйл ажиллагааны төлөвлөгөөг хангах, хувийн төлөвлөлтийг хийх, биелүүлэх, хэрэгжилтийг тайлагнах; 1.2. Аэродром, гэрэл суулт, цахилгааны үйлчилгээ, систем тоног төхөөрөмжийн бэлэн байдал, аюулгүй байдал, чанарын хяналтад өдөр бүр тогтмол хяналт тавих; 1.3. Байгууламжийг шинээр болон дахин суурилуулах, турших, шалгах, түр ажиллуулах, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд хяналт тавих; 1.4. ИНД-ийн журам, зааврын хүрээнд хяналт шалгалтыг хийх, хяналт шалгалтын дагуу нэгдсэн дүгнэлт, зөвлөмж боловсруулах; 1.5. Аэродром, гэрэл суулт, цахилгааны үйлчилгээний байгууллагын аюулгүй байдал, чанарын удирдлагын хяналтыг хангуулах; 1.6. Аэродром, гэрэл суулт, цахилгааны үйлчилгээний байгууллагын чанарын удирдлагын хяналтыг хангуулах; 1.7. ОУИНБ-аас гаргасан аюулгүй байдал, чанартай холбоотой баримт бичигт судалгаа хийх; 1.8. Судалгаанд үндэслэн аюулгүй байдал, чанарыг сайжруулахад чиглэсэн санал боловсруулах, хэрэгжүүлэх шийдлийг гаргаж удирдлагад танилцуулах; 1.9. Тоног төхөөрөмжийн бэлэн байдал, байгууламжийн /аэродром, гэрэл суулт, цахилгааны байгууламжийн/ аюулгүй байдал, эрсдэлийг зөвшөөрөгдөхүйц түвшинд удирдан хянах, осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдал, стандартыг хангаж ажиллах тэдгээрийг хэрхэн дагаж мөрдөж байгааг бататгах, хянах ажлыг зохион байгуулах; 1.10. Үл тохирлыг илрүүлэх, түүний бодит шалтгааныг тодорхойлох, залруулах ажлыг зохион байгуулах;	Холбогдох хууль, дүрэм, журам, зааврууд ыг мөрдөн ажиллаж хэвшсэн байна.	Г Х Г, Х Г, Х Г, Х Г Г Г, Х Г, Х Г
2 дугаар зорилтын хүрээнд	2.1. Аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны баримт бичгийг боловсруулах; 2.2. Аюулгүй байдалтай холбоотой дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэх; 2.3. Дотоод хяналт шалгалтаар илэрсэн дутагдлыг залруулахад чиглэсэн бодит баталгаа бүхий дүгнэлт, зөвлөмжийг боловсруулах, хэрэгжилтийг хянах, үнэлэх; 2.4. Байгууламжийн доголдлын зөрчил, ноцтой гэмтэл болон олон давтагдан гарч буй гэмтлийн бодит шалтгааныг тодорхойлох, дүн шинжилгээ хийх, арилгах дүгнэлт, зөвлөмжийг нэгтгэн боловсруулах; 2.5. Ажилтан болон хамтран ажилладаг байгууллага, хэрэглэгчээс ирүүлсэн аюулгүй байдал, чанарын тогтолцоотой холбогдолтой шаардлага, хүсэлт, гомдолд	Үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлсэн байна. Дотоод хяналт шалгалтаар илэрсэн дутагдлыг залруулахад чиглэсэн дүгнэлт, зөвлөмжийг боловсруулсан байна. Гэрчилгээ олгогч байгууллагын илрүүлсэн зөрчлийг залруулсан,	Г Г Г, Х Г Г

	дүн шинжилгээ хийж, холбогдох арга хэмжээг зохион байгуулах; 2.6. Хөндлөнгийн хяналтын байгууллагын үзлэг шалгалт, дотоод аудит болон аюулгүй байдал, чанарын үзлэг шалгалтын тайлан, зөвлөмж, мэдээллийг хариуцсан чиглэлээрх үйлдвэрлэлийн ажилтнуудад танилцуулах, үзлэг шалгалт, аудитаар илэрсэн үл нийцлийг залруулах арга хэмжээг авах, удирдлагад танилцуулах; 2.7. Технологи үйл ажиллагаа, бүтээгдэхүүн үйлчилгээний бэлэн байдал, найдвартай ажиллагаатай холбоотой судалгаанд дүн шинжилгээ хийх, холбогдох аюулгүй байдал, чанарын гүйцэтгэлийн үзүүлэлтийг (KPIs, SPIs) хэмжиж хянах; 2.8. Технологи, үйл ажиллагаатай холбоотой аюулгүй байдлын талаарх мэдээ, мэдээллийг цуглуулж бүртгэн нэгдсэн сан үүсгэх; 2.9. Бүртгэгдсэн мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, болзошгүй осол, ноцтой зөрчил дутагдал гарах магадлалтай нөхцөл байдлыг тодорхойлох;	шаардлагыг биелүүлсэн байна	Г Г, Х Г Г
3 дугаар зорилтын хүрээнд	3.1. Аэродром, гэрэл суулт, цахилгааны үйлчилгээний төхөөрөмжийн үйл ажиллагааны болзошгүй аюулыг тогтоох, аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг боловсруулах, эрсдэлийг бууруулах арга хэмжээнд хяналт тавих; 3.2. Болзошгүй осол, ноцтой гэмтэл гарах магадлалтай нөхцөл байдлыг мэдсэн тухай бүр шууд удирдах албан тушаалтанд заавал мэдээлэх; 3.3. Аэродром, гэрэл суулт, цахилгааны үйлчилгээний аюулгүй байдлын гүйцэтгэлийн үзүүлэлтийг хянах, үнэлэх, түүнтэй холбогдох дүгнэлт зөвлөмжийг боловсруулах, сайжруулах; 3.4. Аэродром, гэрэл суулт, цахилгааны үйлчилгээнд чанарын хяналт хийх ажлыг удирдан зохион байгуулах;	Аэродром, гэрэл суулт, цахилгааны үйлчилгээний байгууламжийн гэмтэл, хэрэглэгчийн судалгаа, тайлан гүйцэтгэлийн үзүүлэлтэд дүн шинжилгээ хийгдсэн байна.	Г, Х Г Г Г
4 дүгээр зорилтын хүрээнд	4.1. Технологийн баримт бичгийг боловсруулах, хөтлөх, түгээх, ашиглах, өөрчлөх, хадгалах, устгах зэрэг үйл ажиллагааг хянах; 4.2. Осол, зөрчлийн дараа байгууламжийн ажиллагааны байдлыг шалгах, мэдээлэх, бүртгэх зэрэг үйл ажиллагааг хянах; 4.3. Байгууламжийн гэмтэл саатлыг засварлах үйл ажиллагааг хянах; 4.4. Аюулгүй байдал, чанарын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэхэд өөрийн хариуцсан чиглэлээс бусад чиглэлийн үйл ажиллагаанд оролцож, идэвхтэй ажиллах; 4.5. Газрын мэргэжилтнүүдтэй хамтран багаар ажиллаж, аюулгүй байдал, чанарын удирдлагын тогтолцоог сайжруулах шийдэл гаргаж, удирдлагад танилцуулах; 4.6. Хариуцсан чиглэлийн технологич мэргэжилтний эзгүйд ажил үүргийг орлон гүйцэтгэх;	Аюулгүй байдал, чанарын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх, технологи үйл явц, үйл ажиллагаанд идэвх санаачлагатай манлайлан оролцож, багаар хамтран ажилласан байна.	Х Г, Х Х Г Г Г

5 дугаар зорилтын хүрээнд	5.1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж, стандартыг хэрэгжүүлэх, өөрийн харьяалах ажлын байр болон үйлдвэрлэлийн орчинд тохирсон дүрэм, журмыг боловсруулахад оролцох; 5.2 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, зохион байгуулах, хяналт тавих, үр дүнг тооцох, удирдлагын тогтолцоог нэвтрүүлэхэд ажилтнаа манлайлан ажиллах; 5.3 Осолд дөхсөн тохиолдлыг бүртгэх болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, үйлдвэрлэлийн орчинд учирч болох аюулыг илрүүлэх, тогтоох, үнэлэх, бууруулах, арилгах талаар хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтанд мэдээлэх, хамтран ажиллах; 5.4 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27.3, 28 дугаар зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд ажил олгогч болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтантай хамтран ажиллах;	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хангагдсан байна.	Г, Т Г, Х, Т Г, Т Г, Т
Ажлын байрны зорилгын хүрээнд явуулах бусад үйл ажиллагаа	• Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь хэрэгжүүлж ажиллах, гүйцэтгэлийг эргэн тайлагнах; • Удирдлагын цохолтоор ирсэн албан бичгүүдийг хууль, журмын дагуу Монгол хэлний утга зүй, найруулга, дүрмийн алдаагүй, үнэн зөв боловсруулах; • Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, батлуулах, гүйцэтгэлийн тайланг гаргаж, тогтоосон хугацаанд үнэлүүлэх; • Хөдөлмөрийн дотоод журамд тусгагдсан байгууллагын соёл, эрхэмлэх үнэт зүйлс, ажилтны манлайлал, ёс зүйн хэм хэмжээг мөрдлөг болгон ажиллах; • Мэдлэг ур чадвараа дээшлүүлэх талаар идэвх чармайлт, санал, санаачилга гарган ажиллах; • "Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт"-ын дагуу баримт, материалыг архивын нэгж бүрдүүлэн бичиг хэргийн ажилтанд хүлээлгэн өгөх;	Удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгавар, ажлын байрны хүрээнд явагдсан бусад үйл ажиллагаа бүрэн хангагдсан байна.	Г Г Г Г Г Г

III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА		
Боловсрол	Дээд боловсролтой, бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй	
Мэргэжил	Электроник (071401) Мэдээллийн технологи (061304) Компьютерийн техник хангамж (0613) Автоматжуулалт (0714) Цахилгаан хангамж (071310) Аэродромын инженер	
Мэргэшил	• Монгол Улсын мэргэшсэн инженер • Дотоод аудиторын гэрчилгээтэй байх • Аюулгүй байдлын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээжсэн байх • Чанарын удирдлагын тогтолцооны сургалтад хамрагдаж гэрчилгээжсэн байх	
Туршлага	Агаарын навигацийн үйлчилгээний техникийн байгууллагад инженерээр тасралтгүй 5-аас доошгүй жил, аюулгүй байдлын чиглэлээр 5-аас доошгүй жил ажилласан байх	
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	• Мэдээллийн дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх; • Гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах; • Судалгааны ерөнхий арга зүйн мэдлэгтэй байх.

		• Шийдвэрийн шууд болон шууд бус үр дагаврыг үнэлж, шийдлийн хувилбарын талаар зөвлөх.
	Асуудал шийдвэрлэх	• Хуульд нийцсэн, оновчтой, үр дүнтэй шийдвэрийг шуурхай гаргах; • Өөрийн чиг үүргийн хүрээнд шийдлийн хувилбарыг боловсруулж, хариуцах; • Албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд аливаа асуудлыг хууль болон ёс зүйг сахиж, ашиг сонирхлоос аливаа зөрчлөөс сэргийлж, авлига, хүнд суртлаас ангид ажиллах; • Тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, хувилбарыг боловсруулж, түүний эерэг, сөрөг үр дагаврын талаар удирдлагад танилцуулах.
	Манлайлах	• Өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах; • Бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох; • Ажил хэргийн хувьд бүтээлч, санаачилгатай ажиллах; • Өргөн цар хүрээтэй сэтгэж, үлгэрлэн манлайлдаг байх;
	Бусад	• Албан хэрэг хөтлөх, баримт бичиг боловсруулах; • Компьютерийн өргөн хэрэглээний программ хангамж, тоног төхөөрөмжийг ашиглах чадвартай; • Монгол хэл, бичгийн дүрмийн дагуу үг үсгийн болон утга найруулгын алдаагүй бичих; • Монгол бичгийн дунд шатны мэдлэгтэй байх; • Албан тушаалын чиг үүрэгт хамаарах асуудлаар англи хэл, бусад гадаад хэлээр мэдээллийн эх сурвалж ашиглах; • Ачаалал даах чадвартай байх; • Хувийн зохион байгуулалт, цаг ашиглалтын менежмент сайтай байх;

IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:
Аюулгүй байдал, чанарын удирдлагын газрын дарга, үйлдвэрлэл хариуцсан менежер

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:	Бусад харилцах субъект:
- Аэродром, гэрэл суулт, цахилгааны үйлчилгээний аюулгүй байдлын технологич мэргэжилтэн -3	- Иргэний нисэхийн ерөнхий газар - Компанийн харьяа салбар нэгжүүд - Иргэний нисэхийн салбарын бусад байгууллагууд - Хамтран ажиллах гэрээ бүхий гадаад, дотоод байгууллагууд - Ажил хэргийн хүрээнд харилцах бусад байгууллага, иргэд

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:
Албан тушаал: ЗАХИРГАА, САНХҮҮ ХАРИУЦСАН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР Н.ЗОЛЖАРГАЛ 2025 оны 03 дугаар сарын 14-ны өдөр	Байгууллагын нэр: "ИНҮТ" ТӨХХК Шийдвэрийн огноо: 2025.02.18 Дугаар: А/49

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр: "ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ" ТӨХХК

Шийдвэрийн огноо: 2025 оны 03 дугаар сарын 14 өдөр

Дугаар: А/1284
(тамга/тэмдэг)

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ ТӨХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.ОТГОНСҮХ

2025 оны 12 дугаар сарын 14-ны өдөр